

БАТЛАВ.
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД



А.АРИУНЗАЯА

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД



Х.НЯМБААТАР

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг шинэчлэн найруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д насан туршийн суралцахуй, ногоон хөгжил, техник технологийн дэвшилд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх, мэргэшлийн түвшний хүрээг төлөвшүүлэх, багш, хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, тэгш хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх, цахим болон зайн сургалтыг өргөжүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т томоохон бүтээн байгуулалт, үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд бүрэн нийцүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ хотхон, дадлагын бааз байгуулж, санхүүгийн бие даасан байдлыг хангах зорилтыг тусгасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага /ЮНЕСКО/-аас 2019 онд хийсэн “Монгол Улсын мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын бодлогын тойм шинжилгээний тайлан”-д мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлага, санхүүгийн тогтолцоог оновчтой болгох, менежментийн үр нөлөөг дээшлүүлэх, сургалтын хөтөлбөрийг бүх насны хүмүүсийн сургалтын хэрэгцээнд нийцүүлэн хэрэгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг мэргэжлийн боловсрол, сургалтад үр дүнтэй ашиглах зэрэг зөвлөмжийг өгсөн болно.

1.2.Практик шаардлага:

Үндэсний мэргэжилтэй ажилтныг бэлтгэж байгаа мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог бүтээн байгуулалтын томоохон зорилттой уялдуулж, олон улсын жишигт нийцүүлэх, салбар хооронд уялдуулан зохицуулах мэргэжлийн

удирдлагын оновчтой бүтэц шаардлагатай байна.

Гадаад, дотоодын үйлдвэр, ажлын байр болон амьдралын орчноос бие даан эзэмшсэн ур чадвар, чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх, хүлээн зөвшөөрөх, ахисан түвшинд дэвшин суралцахтай холбоотой эрх зүйн зохицуулалт дутмаг, иргэн насан туршдаа суралцах, ур чадвар, мэргэжил эзэмших, мэргэших, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхийн тулд мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн түвшний хүрээг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг чанаржуулах, ажил олгогчтой харилцан ашигтай хамтран ажиллах, мэргэжилтэй ажилтан бэлтгэх салбарын нэр хүнд, үнэлэмжийг өсгөж мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын хэрэгжилтийг хангах, үр дүнг хянаж баталгаажуулах, сургалтын чанарыг тасралтгүй дээшлүүлэх чанарын удирдлагын тогтолцоог бүрэн төлөвшүүлэх хэрэгцээ үүсээд байна.

Аж үйлдвэрийн хувьсгал, ногоон хөгжил, дижитал шилжилт нь салбарын инноваци, судалгаа шинжилгээний чадавхыг дээшлүүлэх бодит шаардлагыг бий болгож байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын багш, хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тасралтгүй хөгжүүлэх тогтолцоо бүрдээгүй байгаа нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байгаа нь нотлогдсон. Сургалтын байгууллагын удирдах ажилтныг бэлтгэх, томилох, тогтвортой ажиллуулах зохицуулалтыг шинэчилж, сургалтын чанарыг хангах чиг үүргийг нэмэгдүүлж, гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулан менежментийн чадавхыг дээшлүүлэх шаардлага үүсэж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын 75 байгууллага 225 мэргэжлээр сургалт эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 60 гаруй хувь нь түгээмэл 40 орчим ижил мэргэжлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэж байгаагаас үзэхэд давхардуулан сургах, эрэлттэй мэргэжлээр ажилтан бэлтгэх хүрээ явцуу, төсөв санхүүжилт, хөрөнгө оруулалтын үр өгөөж тааруу байх зэрэг сөрөг үр дагавар бий болсон.

Иймд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг бүс нутгийн эдийн засгийн бүтэц, үйлдвэржилт, томоохон бүтээн байгуулалт, газар зүйн байршил, хүн амын төвлөрөл, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, сургалтын байгууллагын онцлог, чадавх, нөөц, холбогдох судалгааны үр дүн зэрэг хүчин зүйлийг харгалзан төрөлжүүлэн хөгжүүлэх бодит шаардлага бий болсон.

Мэргэжлийн боловсрол, сургалтын хөгжилд нийгмийн түншлэгч талуудын оролцоо, хариуцлагыг дээшлүүлэх, салбар хоорондын харилцан ашигтай хамтын ажиллагааг хангах зохицуулалтыг тодорхой болгох хэрэгтэй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын төсөв санхүүжилтийг зохицуулсан хуулийн зохицуулалтын уялдаа холбоог хангах, сургалтын байгууллага өөрийн орлогоо захиран зарцуулах боломжийг бий болгосон эрх зүйн орчныг бүрдүүлэх, салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх зохицуулалтыг чанар, үр дүнтэй уялдуулах шаардлагатай байна.

Үйлдвэржилтийн хурдацтай хөгжил, шинэ техник, технологи, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд тавигдах шаардлага, төсвийн зардал байнга өсөж байгаатай уялдуулан мэргэжлийн боловсрол,

сургалтын санхүүгийн удирдлага, төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, салбарын санхүүжилтийг ажил олгогч, түншлэгч болон мэргэжлийн боловсрол, сургалтын харилцаанд оролцогч талуудын хувь, оролцоонд түшиглэсэн, үр өгөөжтэй, олон эх үүсвэртэй болгох шаардлагатай байна.

Дээрх бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаа болон практик шаардлагыг үндэслэн Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх зорилгыг удирдлага болгон боловсруулна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын албан тогтолцоонд энэ ажлыг дагнан эрхэлдэг сургалтын байгууллага (Политехник коллеж, Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, Чадамжийн сургалтын төв) төдийгүй техникийн болон мэргэжлийн боловсролын үйл ажиллагаатай холбогдох дээд боловсрол, ерөнхий боловсролын сургалтын байгууллага хамаарна. Албан бус тогтолцоо нь иргэдийн мэргэжил эзэмших, ур чадвараа дээшлүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд чиглэсэн бие даан болон дагалдан суралцах, мэргэжлийн тохироц, ур чадвараа үнэлүүлэх, баталгаажуулах үйл ажиллагаас бүрдэнэ.

Эдгээр олон талт цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд холбогдох талуудын оролцоотой удирдлага, зохион байгуулалтын бүтэц, эрх, үүргийн хуваарилалтыг энэ хуулиар зохицуулна.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасан шаардлагын дагуу шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулна.

Төсөл нь 7 бүлэгтэй байх бөгөөд 1 дүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, 2 дугаар бүлэгт мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоо, удирдлага, зохион байгуулалт, эрх, үүргийг боловсронгуй болгох, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлыг төрийн захиргааны байгууллага эрхлэх зохицуулалтыг, 3 дугаар бүлэгт, мэргэшлийн түвшний хүрээ бүрдүүлэх, иргэн боловсрол, мэргэшлийн түвшнээ дүйцүүлэх, шатлан суралцах таатай боломж олгох, сургалтын агуулга, стандарт, хөтөлбөрийг боловсруулах, баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих зохицуулалтыг, 4 дүгээр бүлэгт мэргэжлийн боловсрол, сургалтын харилцаанд оролцогчдын эрх, үүргийн хүрээнд сургалтын байгууллагын ангилал, хэв шинжийг нарийвчлан тодорхойлох, багш, суралцагчдын эрх, үүрэг, багшийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх тогтолцоо, сургалтын орчин, тэгш хүртээмжтэй байдлыг хангах, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, идэвхи санаачлагыг нэмэгдүүлэх зохицуулалтыг тус тус тусгана.

Чанарын удирдлага, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тусгай зөвшөөрөл, аттестатчилал, магадлан итгэмжлэл,

үнэлгээ, чанарын баталгаажилтын болон мэргэжлийн боловсрол, сургалтын судалгаа шинжилгээний чадавхийг бүрдүүлэх, салбарын бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа, хөгжлийн хандлагыг судалгаанд суурилан тодорхойлох, томоохон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг төрөлжүүлэн хөгжүүлэх зохицуулалтыг 5 дугаар бүлэгт, мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санг бие даалган ажиллуулах, олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, санхүүгийн хяналтыг дээшлүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага өөрийн орлогоо захиран зарцуулж, байгууллагын хөгжил, багш ажилтны нийгмийн асуудлыг дэмжих боломж олгох зарим шинэ зохицуулалтыг 6 дугаар бүлэгт тусгана.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, болон бусад зохицуулалтыг 7 дугаар бүлэгт тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

1.Хөгжлийн шаардлага, олон улсын жишигт нийцсэн мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлагын тогтолцоо бүрдэж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь үйлдвэржилтийн хөгжил бүс нутгийн эдийн засгийн онцлогт тулгуурлан төрөлжин хөгжиж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050"-д дэвшүүлсэн зорилтын хүрээнд төр-хувийн хэвшлийн түншлэлийн үр нөлөө дээшилж хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэжилтэй ажилтны эрэлт, хэрэгцээ хангагдаж зохистой харицаа бүрдэнэ.

2.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын ангилал, хэв шинж, бүтэц боловсронгуй болж, ногоон-хөгжил, аж үйлдвэрийн хувьсгал, дижитал шилжилт нь чанарын өөрчлөлтийг бий болгоно.

3.Багш, хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх тогтолцоо шинээр бүрдэнэ.

4.Иргэн мэргэжлийн боловсрол, сургалтын чанартай, тэгш хүртээмжтэй, жендэрийн мэдрэмжтэй үйлчилгээ хүртэж, хүсэл сонирхолдоо нийцсэн мэргэжил эзэмшиж, мэргэшлийн ур чадвараа дээшлүүлэх, үнэлүүлэх ижил боломж, үүнтэй холбоотой нийгмийн баталгаагаар хангагдана.

5.Сургалтын стандарт, хөтөлбөрийг мэргэжлийн стандартад нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх, ажил олгогчтой хамтран төгсөгчдийн мэргэшлийн ур чадварыг үнэлэх мэргэжлийн боловсрол, сургалтын насан туршийн сургалтын тогтолцоо хөгжинө.

6.Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн түвшний хүрээг бүрдүүлж, чанарын баталгаажилтын тогтолцоог бий болгоно.

7.Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын судалгаа шинжилгээний чадавх сайжирч, судалгаанд суурилан шийдвэр гаргах үйл ажиллагаа төлөвшинө.

8. Мэргэжлийн боловсрол, сургалтын мэдээллийн нэгдсэн сан бүрдэж, төр, иргэн, аж ахуйн нэгж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, олон нийт хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн бодит мэдээллээр хангагдана.

9. Мэргэжлийн боловсрол, сургалтын олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоо бүрдэнэ. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн эрх зүйн зохицуулал боловсронгуй болж, хувийн хэвшлийн санхүүгийн дэмжлэг бүрдсэнээр санхүүжилтийг төр дангаараа хариуцаж ирсэн хуучин практик өөрчлөгдсөнөөр сургалт, дадлагын чанарыг дээшлүүлэх, мэргэжлийн ур чадвартай мэргэжилтэй ажилтанг бэлтгэж хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэхэд бодитой ахиц гарна. Сургалтын байгууллага өөрийн орлогоо захиран зарцуулах зохицуулалтыг тусгаснаар байгууллагаа хөгжүүлэх, багш, ажилтны нийгмийн баталгааг хангах боломж өргөжинө.

10. Хуулийн давхардал, хийдэл, зөрчил, арилж, мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааны хяналт, хариуцлагын тогтолцоо боловсронгуй болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцсэн байх бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай анхны бие даасан хуулийг УИХ 2002 онд баталж, 2009 онд шинэчилсэн найруулга хийж өнөөг хүртэл мөрдөн хэрэгжүүлж ирсэн. Хуулийг хэрэгжүүлэх явцад 2012, 2015, 2016 онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан юм.

Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ зорилтуудыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын багш нарын Улсын анхдугаар Зөвлөгөөн”-ий шийдвэр, УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2018 оны 17 дугаар тогтоол, “Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 388 дугаар тогтоолд салбарын шинэчлэлийн томоохон зорилтууд тусгагдсан. НҮБ-аас техник мэргэжлийн боловсрол нь “Иргэн мэргэжил эзэмших, ур чадвараа хөгжүүлэх, амьдралын чанараа ахиулах, тогтвортой хөгжилд хөтлөх хөдөлгүүр” гэж тодорхойлсон.

Эдгээр нь эрх зүйн орчныг шинэчилж өөрчлөх үндэслэл болж байна.

Иргэн өөрийн сонирхол, ажил амьдралдаа хэрэгцээтэй мэргэжил эзэмших, ур чадвараа тасралтгүй дээшлүүлэхэд чиглэсэн нээлттэй, хүртээмжтэй, чанартай мэргэжлийн боловсрол, сургалтын үйлчилгээг үзүүлэх замаар улс орны эдийн засаг, бүтээн байгуулалтын тулгуур-хөгжлийн зүтгүүр болсон ажиллах хүчээр хангахад хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үндсэн агуулга чиглэж байна.

Хуулийн төслийг боловсруулах хүрээнд өргөн хэмжээний судалгаа, шинжилгээ хийж, холбогдох тайлан, зөвлөмжүүдийг ашигласан. Үүнд:

- Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын тойм судалгааны тайлан. ЮНЕСКО, ХНХЯ. 2019 он
- “Техник мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний форум” зөвлөмж. ЮНЕСКО, ХНХЯ. 2019 он
- “Гадаадын зарим орны мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх хуулийн зохицуулалт” харьцуулсан судалгаа. УИХ-ын Тамгын газрын судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв. 2009 он
- “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”, Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-I, II. АХБ. 2018, 2019 он
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институтын тайлангууд.
- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төрөлжүүлэн хөгжүүлэх талаар хийсэн судалгааны тайлангууд. АХБ 2018 он, Европын холбоо, Мэргэжлийн боловсрол, сургалт-Түншлэл ТББ, Техник мэргэжлийн боловсрол, сургалтын хөгжлийн ассоциаци, IRIM судалгааны хүрээлэн, 2015-2019 он. ГОУХАН 2020 он
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан. ХНХЯ. 2020 он

Хуулийн төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтран баталсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”-д нийцүүлэн боловсрууллаа. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийг боловсруулж, холбогдох зардлын тооцоог хийж гүйцэтгэсэн.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 7 бүлэг, 32 зүйлтэй. Одоо мөрдөж байгаа хуультай харьцуулахад бүлгийн тоо 2, зүйлийн тоо 4-р тус тус нэмэгдсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, удирдах ажилтан, ажил олгогч, судлаач, эрдэмтэд, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажилласан бөгөөд хуулийн төслийг нийт 75 сургууль, 100 гаруй түншлэлийн байгууллага, мэргэжлийн холбоодоор хэлэлцүүлсэн.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн гол, онцлог зохицуулалт:

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго: “Иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино” гэж тодорхойлсон.

Энэхүү зорилгод үндэслэн мэргэжил эзэмших, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх тэгш боломжийг олгосон, зөв хандлагатай, хөдөлмөрийн хүнийг төлөвшүүлэх иргэнд хандсан мэргэжлийн боловсрол, сургалтын үйлчилгээг үзүүлэх концепцийг баримтлан хуулийн төслийг боловсруулав.

2. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлыг төрийн захиргааны байгууллага эрхлэх шинэ зохицуулалт: Засгийн газрын 2019 оны 388 дугаар тогтоолд “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд одоо ажиллаж байгаа бүтэц, орон тоонд түшиглэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Мэргэжлийн боловсрол, сургалтын ерөнхий газар шинээр байгуулах талаар судлан танилцуулах” гэж заасан нь энэхүү зохицуулалтын эрх зүйн үндэслэл болж байна.

Дэлхий улс орнууд мэргэжлийн боловсрол, сургалтын салбараа хөгжүүлэх, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгоход онцгойлон анхаарч байна. ЮНЕВОК-ийн гишүүн 195 орныг хамруулан хийсэн судалгааны дүнгээс үзэхэд тэдгээр орны 71.2 хувьд мэргэжлийн боловсрол, сургалтыг Засгийн газрын агентлаг түүнтэй адил төстэй байгууллага хариуцдаг байна. (ОХУ, БНХАУ, БНСУ, Япон, Сингапур, Малайз, Филиппин, Дани, Австрали, Финлянд)

Бүтээн байгуулалт, үйлдвэрлэлийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахуйц мэргэжилтэй ажилтан бэлтгэх, салбар хоорондын зохицуулалт хийх шаардлагыг харгалзан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ажиллуулснаар мэргэжлийн удирдлагын үүрэг, хариуцлага өндөржих, сургалтын байгууллага, багш, иргэд, ажил олгогч, түншүүдэд хүрч ажиллах боломж бүрдэнэ.

Мэргэжлийн боловсрол, сургалтын төрийн захиргааны байгууллага байгуулснаар төсөв, хөрөнгө, орон тоо нэмэгдэхгүй бөгөөд одоогийн төсөвт багтаан ажиллуулах боломжтой.

3. Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгын шинэ бодлогыг хэрэгжүүлэх зохицуулалт: Сургалтын агуулгыг ажил, мэргэжлийн стандарт, мэргэшлийн түвшин бүрд нийцсэн мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, сургалтын хөтөлбөрөөр зохицуулахаар заасан.

Иргэний мэргэжил сонголтод туслах тохироцын үнэлгээ хийх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажил хөдөлмөрт бэлтгэх, мэргэжил эзэмших, ур чадвараа үнэлүүлэх,

баталгаажуулах, хөгжүүлэх насан туршийн суралцахуйг дэмжсэн агуулгын залгамж холбоог хангаж байхаар туссан байна.

Аж ахуйн нэгж, байгууллага дээрх үйлдвэрлэлийн дадлагаар олгох мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн соёл, төлөвшилд онцгой ач холбогдол өгч, дадлагыг чанартай зохион байгуулах, өндөр мэргэшсэн инженер техникийн ажилтан-дадлагажуулагчийн үүрэг, хариуцлагыг журамлан зохицуулахаар тусгав. Мөн мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх эрх, үүргийг хуулийн төсөлд шинээр тусгалаа.

Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрт эх хэл, түүх, соёл, эх оронч үзэл, жөндөрийн тэгш байдлыг хангах болон байгаль орчинд ээлтэй, ногоон сургалт, үйлдвэрлэл эрхлэх чадвар, гамшгаас хамгаалах агуулгыг заавал эзэмшихээр тусгасан.

Иргэн гадаад, дотоодын үйлдвэрлэлийн орчинд олж авсан мэдлэг, ур чадвараа үнэлүүлж зохих түвшний чадамжийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх, диплом авч хөдөлмөр эрхлэх боломж олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн түвшний хүрээг тодорхойлон хэрэгжүүлж, иргэн эзэмшсэн мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвартаа тохирсон ажил эрхлэх, хөрвөж ажиллах зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж оруулсан.

4. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын эрх хэмжээ, чиг үүрэг:

Одоогийн мөрдөж буй хуулиар сургалтын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг зохицуулсан ч түүний эрх, үүрэг, хариуцлагын зохицуулалт дутмаг байгааг судалгаа харуулсан. Үүнтэй холбогдуулан мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын чиг үүргийг сургалтын чанар, мэргэжлийн ур чадварт чиглүүлэх зохицуулалтыг нэмж тусгасан.

Аж үйлдвэрийн IV хувьсгал, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн дижитал шилжилтийг хийх, сургалтыг цахим, зайн хэлбэрээр зохион байгуулах зохицуулалтыг анх удаа тусгасан.

Өнөөгийн байдлаар мэргэжлийн боловсрол, сургалтын 75 байгууллага 225 мэргэжлээр сургалт явуулж байна. Тэдгээрийн 60 гаруй хувь нь түгээмэл 40 орчим мэргэжлээр мэргэжилтэй ажилтан давхардуулан бэлтгэж байна. Энэ нь төгсөгч ажлын байртай болоход сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй, хөдөлмөрийн зах зээлд нэн эрэлттэй мэргэжилтэй ажилтан бэлтгэх боломжийг багасгаж байна. Иймд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, сургалтын байгууллагын чадавхид тулгуурлан мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж хөгжүүлэх заалтыг хуулийн төсөлд шинээр тусгаж байна.

Сургалтын байгууллага үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх нэгж, бизнес инкубатар, туслах аж ахуйтай байж болохоор заасан. Эдгээр үйл ажиллагаанаас олсон орлогыг төрийн санд төвлөрүүлдэг учир эргүүлэн авч захиран зарцуулахад хүндрэлтэй байдгаас сургалтын байгууллагуудын орлого олох идэвхи санаачилга буурсан. Иймээс сургалтын байгууллага өөрийн үйл ажиллагаанаас олсон орлогоо захиран зарцуулах эрх олгох зохицуулалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталсан журмын дагуу шийдвэрлэхээр тусгасан.

5. Мэргэжлийн боловсрол, сургалтын багшийн асуудлаар тусгасан шинэ зохицуулалт: Өнөөг хүртэл мэргэжлийн боловсрол, сургалтын багшийг шинээр бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх тогтолцоо бүрэлдээгүй байгаа нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байна.

Иймд мэргэжлийн боловсрол, сургалтын багш бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх тогтолцоог бүрдүүлэх зохицуулалтыг хуульд шинээр орууллаа.

Багш сургалтын идэвхитэй, шинэлэг арга зүйг эзэмших, мэргэжлийн багш аж ахуйн нэгж, байгууллагад жил бүр үйлдвэрлэлийн орчинд дадлага хийж ур чадвараа ахиулах,

гадаад хэл, дижитал ур чадварт суралцах, хоёр жил тутамд мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, гурван жил тутамд мэргэшил, ур чадвараа үнэлүүлэх зэрэг шинэ зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгалаа.

6. Чанарын баталгаажилт: Энэ бүлгийг шинээр нэмж орууллаа. “Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын хэрэгжилтийг үнэлэх, баталгаажуулах, иргэдийн мэргэжлийн ур чадвар, аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх баталгааг хангах үндсэн хэрэгсэл нь мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажилтын тогтолцоо байна” гэж тодорхойлсон.

Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажилтын тогтолцоонд тусгай зөвшөөрөл, атестатчилал, мэргэшлийн баталгаажуулалт, магадлан итгэмжлэл, гэрчилгээжүүлэлтийн үйл ажиллагаа хамаарна гэж хуулийн төсөлд шинээр тусгасан.

Салбарын чанарын баталгаажилтыг хариуцах чиг үүргийг үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв хэрэгжүүлж хөндлөнгийн үнэлгээ хийх, судалгаа шинжилгээ эрхлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, цахим мэдээллийн нэгдсэн сан ажиллуулах, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, багш нарт зөвлөн туслах чиглэлээр ажиллах зохицуулалт хийсэн.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөр, багшлахуйн болон сургалтын үйл явц, үр дүн, үйл ажиллагаандаа тогтмол үнэлгээ хийж, чанарын дотоод баталгаажуулалтыг хангаж ажиллах чиг үүргийг хуулийн төсөлд шинээр тусгасан.

7. Мэргэжлийн боловсрол, сургалтын төсөв, санхүүжилтийн шинэ зохицуулалт: Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээний тайлан, Монгол Улсын Их Хурлын НББСШУ-ны байнгын хорооны 2018 оны 17 дугаар тогтоолоос үзвэл мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санг үр дүнтэй ажиллуулах эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэх механизм дутагдалтай гэж дүгнэсэн байна.

Судалгаа, шинжилгээний тайлан, зөвлөмжид үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн санхүүгийн удирдлагыг мэргэжлийн боловсролын төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэх, сангийн орлого зарлагын зохицуулалтыг тодорхой болгох өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгасан.

ХБНГУ, Дани, БНХАУ, Япон, Филиппин, Малайз зэрэг олон орон мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, түүнтэй адил төстэй байгууллагыг амжилттай ажиллуулснаар мэргэжилтэй ажилтан бэлтгэх санхүүжилтийг төр дангаараа хариуцаж ирсэн тогтолцоог өөрчилж, олон эх үүсвэр бүхий санхүүжилтийг буй болгожээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтын төсөв, санхүүжилтийг төлөвлөж байгаа аргыг шинэчлэх нь тулгамдсан асуудлын нэг болж байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардал, түүнийг тооцох аргачлалыг үндэслэлтэй тогтоогоогүйгээс сургалтын байгууллагын төсөв, санхүүжилт дутмаг байгаа нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлөхөд хүрсэн. Иймд хувьсах зардал, тооцох аргачлалыг мэргэжлийн боловсрол, сургалтын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар хуулийн төсөлд тусгалаа.

Хуулийн нэр томъёоны зөрчил, давхардлыг арилгаж, дагалдах хуулийн төслүүдийг боловсруулсан болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго, агуулга, удирдлага, зохион байгуулалт, мэргэжлийн боловсрол, сургалтын харилцаанд оролцогчдын эрх зүйн байдлыг тогтооходой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомж

2.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Засгийн газрын тухай, Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь өмчийн аль ч хэлбэрт түшиглэн мэргэжлийн боловсрол, сургалтыг албан болон албан бус хэлбэрээр зохион байгуулах хуулийн этгээдэд хамаарна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "үндэсний мэргэшлийн хүрээ" гэж мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, төлөвшлийг ангилан төрөлжүүлэх, түвшнээр нь эрэмбэлэх, хүлээн зөвшөөрөх, хөгжүүлэх арга хэрэгслийг;

4.1.2. "мэргэшлийн түвшин" гэж ажилтны эзэмших мэдлэг, чадвар, гүйцэтгэх ажил, үүргийн төлөвшил, хариуцлага, хандлагын хүрээг стандартаар тодорхойлсон мэргэшлийн шатлалыг;

4.1.3. "мэргэжил" гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг;

4.1.4. "мэргэшил" гэж тодорхой мэргэжлийн хүрээнд ажил гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, ур чадвар, дадлын түвшинг;

4.1.5. "мэргэжлийн боловсрол" гэж тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг;

4.1.6. "техникийн боловсрол" гэж техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн үйлдвэрлэл, техник, технологийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг;

4.1.7. "чадамжийн сургалт" гэж ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах тодорхой ур чадвар олгох, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх, аж ахуй эрхлэх мэдлэг олгох үйл ажиллагааг;

4.1.8. "мэргэшүүлэх сургалт" гэж иргэний мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах үйл ажиллагааг;

4.1.9. "чадамж" гэж хөдөлмөрийн орчинд ажил олгогчийн зүгээс тавих мэргэжлийн шаардлагыг биелүүлэх түвшинд суралцагчийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, ур чадвар, дадал, хөдөлмөрийн соёлын төлөвшлийг;

4.1.10. "чадамжийн нэгж" гэж тодорхой ажил, мэргэжлийн чадамж эзэмшүүлэхэд чиглэсэн харилцан уялдаа бүхий сургалтын нэгж ажилбарыг;

4.1.11. "чадамжийн үнэлгээ" гэж хувь хүний мэдлэг, ур чадвар, төлөвшлийг, тогтоосон шалгуурын дагуу тодорхойлох үйл явцыг;

4.1.12. "чадамжийн сан" гэж ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт, ажил мэргэжлийн лавлахад нийцүүлэн бүрдүүлсэн тухайн мэргэжилд хамаарах ажилбарын жагсаалт, сургалтын хөтөлбөрийн агуулгыг багтаасан нэгдсэн мэдээллийг;

4.1.13. "сургалтын хөтөлбөр" гэж мэргэжлийн боловсрол, сургалтын стандартыг хэрэгжүүлэхэд баримтлах удирдамж, арга зүйн баримт бичгийг;

4.1.14. "чанарын баталгаажилт" гэж мэргэжлийн боловсрол, сургалтыг стандартад нийцүүлэх, чанарыг тасралтгүй дээшлүүлэх, үр дүнг баталгаажуулахад чиглэсэн үйл ажиллагааны цогцыг;

4.1.15. "сургалтын орчин" гэж мэргэжлийн боловсрол, сургалтын стандартыг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг нөхцөлийг;

4.1.16. "ногоон чадвар" гэж үйл ажиллагааны зохицуулалтын уламжлалт хэлбэрээс байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээнд шилжих чадварыг;

4.1.17. "жөндөр", "жөндөрийн эрх тэгш байдал", "жөндөрийн хэвшмэл үзэл", "жөндөрийн ялгаварлан гадуурхалт" гэсэн нэр томъёог Жөндөрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар ойлгоно.

4.2. Мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалт, түүнчлэн энэ хуулийн 4.1.6-д заасан үйл ажиллагааг хамтад нь мэргэжлийн боловсрол, сургалт гэж ойлгоно.

5 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго

5.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТОГТОЛЦОО,
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлагын тогтолцоо

6.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлагын тогтолцоо нь мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв, сургалтын байгууллагаас бүрдэнэ.

6.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлагын тогтолцоо, бүтэц зохион байгуулалттай холбоотой шийдвэр гаргахад Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэнэ.

6.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) нь мэргэжлийн боловсрол, сургалтын хөгжлийн бодлого, стратегийг тодорхойлох, хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн тэнцвэртэй оролцоог хангаж, тогтвортой ажиллах баталгааг бүрдүүлсэн орон тооны бус байгууллага байна.

6.4. Зөвлөл нь мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг хэрэгжүүлнэ. Зөвлөл нь ажлын албатай байна.

7 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

7.1. Боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн, түүнчлэн бусад төрийн захиргааны төв байгууллага нь хуулиар тогтоосон эрхлэх асуудлын чиглэлээр мэргэжлийн боловсрол, сургалтыг бодлогоор дэмжиж, энэ хуулийн 6.3-т заасан Зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

7.4. Эрхэлсэн салбарт хэрэгцээтэй мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх талаар төрийн захиргааны төв байгууллагын захиалгыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэгтгэн зохицуулна.

7.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах чиг үүрийг хэрэгжүүлнэ:

7.3.1. салбарын бодлого, стратегийг тодорхойлох, мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, энэ хуулийн 8.1-д заасан төрийн захиргааны байгууллагыг удирдлагаар хангах;

7.3.2. мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн даргыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх, албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, дүгнэх;

7.3.3. мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн бүтэц, орон тоо, дүрмийг хянах, эрх бүхий байгууллагаар батлуулах;

7.3.4. чадамжийн сургалтын төвийг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох, хяналт тавих журмыг батлах.

8 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний бүрэн эрх

8.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх төрийн бодлого, Засгийн газрын болон энэ хуулийн 6.3-т заасан Зөвлөлийн шийдвэрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага байна.

8.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 6.3-т заасан Зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ.

8.3. Энэ хуулийн 8.1-т заасан төрийн захиргааны байгууллагын даргыг Засгийн газрын тухай хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.

8.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.4.1. мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх чиглэлээр төрийн бодлого, үндсэн чиглэл, ойрын болон хэтийн төлөвлөгөө, дүрэм, журам, зааврыг боловсруулах, хэрэгжүүлэх;

8.4.2. мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;

8.4.3. мэргэжлийн болон техникийн боловсролын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нийцүүлэн төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

8.4.4. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, хууль тогтоомжид заасан дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

8.4.5. мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, өөрчлөх, цуцлах, ангилал тогтоох талаар дүгнэлт гаргах;

8.4.6. төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захирлыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх, албан тушаалын тодорхойлолтыг батлах;

8.4.7. төрийн бус өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захиралтай гэрээ байгуулах, дүгнэх;

8.4.8. мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын хүний нөөц, суралцагчдын нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтэд зохицуулалт хийх;

8.4.8. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, ажилтныг бэлтгэх, даван сургах, мэргэшүүлэх тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах;

8.4.9. мэргэжлийн боловсрол, сургалтын стандартыг боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

8.4.10. мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих;

8.4.11. сургалт-үйлдвэрлэл, үйлдвэрлэл-сургалтын явцад шинэ технологи, шинжлэх ухаан, техникийн ололт, дэвшлийг нэвтрүүлэх, дижитал шилжилтийг хэрэгжүүлэх;

8.4.12.мэргэжлийн боловсрол, сургалтын сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангах, сургалтын орчныг сайжруулах бодлого, чиглэлийг боловсруулж батлах;

8.4.13.мэргэжлийн боловсрол, сургалтын мэдээллийн нэгдсэн сан, статистик бүрдүүлэх, хөтөлж ахлыг удирдлагаар хангах;

8.4.14.мэргэжлийн болон техникийн боловсролын асуудлаар шаардлагатай мэдээ тайлан, тооцоо судалгааг төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

8.4.15.мэргэжлийн болон техникийн боловсролын асуудлаар олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээрээр Монгол Улсын Засгийн газрын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, зохицуулах;

8.4.16.мэргэжлийн боловсрол сургалтын асуудлаар гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

8.4.17.энэ хуулийн 7.3.4-т заасан журмыг хэрэгжүүлэх, хяналт тавих;

8.4.18.мэргэжлийн болон техникийн боловсролын чиглэлээр хийгдэх төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар хариуцуулан гүйцэтгэх талаар судлах, санал боловсруулах;

8.4.19.энэ хуулийн 8.4.18-д заасан чиглэлээр хийгдсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

8.4.20. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

9 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн чиг үүрэг

9.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв нь мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг боловсронгуй болгох, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах, түгээх, арга зүйн удирдлагаар хангах, сургалт, судалгаа эрхлэх, хүний нөөцийг чадавжуулах, иргэний албан ба албан бус хэлбэрээр эзэмшсэн мэдлэг, ур чадварыг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөгжүүлэх, чиг үүрэгтэй байна.

9.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв нь бүсийн арга зүйн нэгж, мэргэжлийн чиглэлээр төрөлжсөн зөвлөлтэй (цаашид "мэргэжлийн зөвлөл" гэх) байна. Нэгжийн үйл ажиллагааны дүрмийг 9.1-д заасан төвийн дарга батална.

9.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.3.1.мэргэжлийн боловсрол, сургалтын стандартыг багш, ажилтан, мэргэжлийн холбоо, ажил олгогчийн оролцоотойгоор боловсруулах;

9.3.2.сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хянах, арга зүйн зөвлөмжөөр хангах;

9.3.3.агуулгын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр сургалтын байгууллага, багш, ажилтанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах;

9.3.4.мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх;

9.3.5.мэргэжлийн болон техникийн боловсролын сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, бэлтгэх, түгээх ажлыг зохион байгуулах;

9.3.6.багш, ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангах;

9.3.7.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад багшлах, багш мэргэжлээр төгсөөгүй иргэнд сургах зүйн чадамж эзэмшүүлэх сургалт хийх, багшлах эрх олгох үйл ажиллагааг энэ хуулийн 16.2.4-д заасан журмын дагуу зохион байгуулах;

9.3.8.багшийн мэргэшлийн ур чадварын түвшин тогтоох, үнэлгээ хийх,

9.3.9.үнэлгээ, баталгаажуулалтын болон агуулга, арга зүйн ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах;

9.3.10.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагч, төгсөгч, мэргэшлийн ур чадвар эзэмшсэн иргэн, мэргэжилтэй ажилтны мэргэшлийн түвшний үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх, үйл ажиллагааг холбогдох мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран зохион байгуулах;

9.3.11.хувь хүн өөрийн авъяас, боломжоо нээж, ажил мэргэжлийн сонголтоо зөв хийхэд нь туслах мэргэжлийн тохиоцын үнэлгээ хийх;

9.3.12.салбарын судалгаа, шинжилгээний чадавхийг бий болгох, судалгааны ажлыг эрхлэх, зөвлөмжөөр хангах;

9.3.13.ур чадвар, ажил мэргэжлийн уралдаан тэмцээнийг мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН АГУУЛГА, СТАНДАРТ

10 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга

10.1 Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга нь суралцагчийн сонирхол, авъяас, хөдөлмөр эрхлэх хэрэгцээ, ажил олгогчийн эрэлтэд суурилж, боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлага, шинжлэх ухаан, технологийн хөгжилд нийцүүлэн мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх, мэргэшүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёлыг төлөвшүүлэх мэргэжлийн боловсрол, сургалтын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

10.2 Мэргэжлийн болон техникийн боловсролын стандарт, хөтөлбөрт эх хэл, түүх, соёл, эх оронч үзэл, жөндөрийн тэгш байдлыг хангах болон байгаль орчинд зэлтэй ногоон чадвар, үйлдвэрлэл эрхлэх чадвар эзэмшүүлэх, гамшгаас хамгаалах агуулгыг тусгана.

10.3 Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгыг техникийн боловсролын, мэргэжлийн боловсролын, чадамжийн сургалтын гэж ангилна.

10.4. Техникийн боловсролын сургалтын агуулга нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, технологийн процессыг удирдахад шаардагдах мэдлэг, дадал, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлыг төлөвшүүлэхэд чиглэнэ.

10.4.1.техникийн боловсролын сургалтын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хэсгээс бүрдэнэ.

10.4.1.1.ерөнхий суурь хэсгийн агуулга нь суралцагч техникийн боловсролын шинжлэх ухааны үндсийг эзэмших;

10.4.1.2.мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагч техник, технологийн нийтлэг онол-арга зүйн мэдлэг, чадварыг эзэмших;

10.4.1.3.мэргэшүүлэх хэсгийн агуулга нь суралцагч тодорхой салбар, ажлын байранд мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх, зохион байгуулахад шаардагдах мэдлэг, ур чадвар, дадлыг эзэмшихэд чиглэнэ.

10.5. Мэргэжлийн боловсролын сургалтын агуулга нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах мэдлэг, дадал, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлыг төлөвшүүлэхэд чиглэнэ.

10.5.1.мэргэжлийн боловсрол олгох сургалтыг бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалттай хослуулан зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд бүрэн дунд боловсролын агуулга нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан зорилтод нийцсэн байна.

10.5.2.мэргэжлийн боловсролын сургалтын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хэсгээс бүрдэнэ:

10.5.2.1.ерөнхий суурь хэсгийн агуулга нь суралцагч мэргэжил, боловсрол, эзэмшихэд зайлшгүй шаардлагатай мэргэжлийн үндсийг эзэмших;

10.5.2.2.мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагч үйлдвэрлэл, үйлчилгээ, техник, технологийн чиглэлээр зайлшгүй шаардлагатай суурь мэдлэг, ур чадвар, дадлыг эзэмших;

10.5.2.3.мэргэшүүлэх хэсгийн агуулга нь суралцагч тодорхой түвшний мэргэжлийн үйл ажиллагааны мэдлэг, ур чадвар, дадал эзэмших.

10.6. Энэ хуулийн 10.5.1-д заасан бүрэн дунд боловсролын заавал судлах агуулгыг мэргэжлийн боловсрол олгох ерөнхий суурь хэсэгт тусган эзэмшүүлнэ.

10.7. Мэргэшүүлэх сургалтын агуулга нь иргэний мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах тодорхой түвшний чадамж эзэмшүүлэхэд чиглэнэ.

10.8. Чадамжийн сургалтын агуулга нь тодорхой түвшний мэдлэг, дадал, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн чадамжийн нэгжээс бүрдэнэ.

10.9. Техникийн болон мэргэжлийн боловсролын агуулгыг дээд боловсролын сургалтын агуулгатай уялдуулах асуудлыг энэ хуулийн 8.1-д заасан байгууллага зохион байгуулна.

10.10. Боловсролын тухай хуулийн 3.1.18-д заасны дагуу энэ хуулийн 10.5.1-д заасан бүрэн дунд боловсролын хөтөлбөрийн заавал судлах агуулгыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

11 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт

11.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт нь сургалтын агуулга, үнэлгээ, багш, сургалтын орчинд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлно.

11.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын ерөнхий шаардлага, загварыг Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6.5-д заасны дагуу баталж, улсын бүртгэлд бүртгэнэ.

12 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөр

12.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь мэргэшлийн түвшин бүрт тохирсон, мэргэжлийн боловсрол, сургалтын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөртэй байна.

12.2. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тавигдах нийтлэг шаардлага, загварыг Мэргэжлийн боловсрол, сургалтын төрийн захиргааны байгууллага батална.

12.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь сургалтын стандарт, хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөг боловсруулан сургалт-үйлдвэрлэлийн зөвлөлөөр хэлэлцүүлж сургуулийн захирал батална.

12.4. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сургалтын байгууллага боловсруулан хэрэгжүүлнэ.

13 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын зохион байгуулалт

13.1. Мэргэжлийн боловсрол, сургалт нь хосмог, өдөр, оройн, эчнээ хэлбэртэй байж болно.

13.2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг танхимын болон танхимын бус (зайн, цахим), үйлдвэрлэлийн сургалт, үйлдвэрлэлийн дадлага хэлбэрээр зохион байгуулна.

13.3. Үйлдвэрлэлийн сургалтыг сургалтын байгууллага дээр, үйлдвэрлэлийн дадлагыг ажлын байранд зохион байгуулна.

13.4. Үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулахдаа аж ахуйн нэгж, суралцагч, сургалтын байгууллага гурван талт гэрээ байгуулж хамтарсан хариуцлага хүлээнэ.

13.5. Гамшгийн улмаас танхимын сургалтын үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын шийдвэрээр түр зогсоох тохиолдолд сургалтыг танхимын бус хэлбэрээр зохион байгуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧИД

14 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага

14.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн чадамж олгох, мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх, мэргэшүүлэх үүрэг бүхий байгууллага байна.

14.2. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм, жишиг бүтэц болон байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үлгэрчилсэн дүрмийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж мөрдүүлнэ.

14.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг бүсчилсэн хөгжлийн бодлого, эдийн засгийн бүтэц, үйлдвэржилтийн төрөлжилт, хүн амын төвлөрөл, газар нутгийн байршлыг харгалзан мэргэжлийн чиглэлээр төрөлжүүлнэ.

14.4. Сургалт, үйлдвэрлэлийн үлгэр жишээ орчин бүхий жишиг цогцолборыг салбар дундын дадлагын бааз, хотхон хэлбэрээр ажиллуулж болно.

14.5. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь чиг үүргээсээ хамааран техникийн боловсролын, мэргэжлийн боловсролын болон чадамжийн сургалтын гэсэн ангилалтай байна.

14.6. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь дараах хэв шинжтэй байна:

14.6.1.техникийн боловсролын сургалтын байгууллага нь политехник коллеж байна. Технологийн коллеж түүнтэй адилтгах хөтөлбөр бүхий сургалтын байгууллагыг энэ ангилалд хамааруулна. Политехник коллеж нь харьяалалдаа мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагатай байж болно;

14.6.1.1.политехник коллеж нь сургалтын төрөлжсөн чиглэлээр шинэ хөтөлбөр, судалгаа шинжилгээ, инновацийг нэвтрүүлэх, багшийг мэргэшүүлэх, захиалгат сургалт явуулах, ур чадварыг үнэлэх, хөгжүүлэх чадамжийн төвтэй байж болно;

14.6.1.2.чадамжийн төв байгуулах шалгуур үзүүлэлт, үйл ажиллагааны журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална;

14.6.2.мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв байна. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь харьяалалдаа сургалтын төвтэй байж болно;

14.6.3.мэргэжлийн боловсрол олгох тусгай сургууль нь мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв байна.

14.6.4.чадамжийн сургалт эрхлэх байгууллага нь сургалтын төв, үйлдвэрлэлийн харьяалалтай сургалтын төв, тусгай хэрэгцээт сургалтын төв байна.

15 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчин, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн

15.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь сургалтын орчны стандартын шаардлага хангасан хичээлийн танхим, лаборатори, дадлагын газар, сургалтын талбай, туршилт-үйлдвэрлэлийн цех, сургалтын аж ахуй, багшийн хөгжлийн төв, номын сан, дотуур байр, соёл-спортын болон мэдээллийн төвтэй байна.

15.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлдвэрлэл-үйлчилгээ эрхлэх нэгж, бизнес инкубатор, туслах аж ахуйтай байж болно.

15.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь Боловсролын тухай хуулийн 42.1, 42.5, 42.6 дахь хэсэг, мэргэжлийн боловсрол, сургалтын орчны стандартад заасан шаардлагыг хангасан байна.

15.4. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд тохирох хүртээмжтэй дэд бүтэц, ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангана.

16 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын харилцаанд оролцогч тагуудын эрх, үүрэг

16.1. Сургалтын байгууллага:

16.1.1.сургалтын байгууллага нь хууль, тогтоомжийн дагуу бие даасан байдлаа хангах, суралцагч, багш, ажилтны эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаагаа улс төр, шашнаас ангид явуулах, санхүүгийн өөрийн орлогоо захиран зарцуулах;

16.1.2.сургалтын байгууллагыг хөгжүүлэх бодлого, стратеги төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, иргэний мэргэжил, ур чадвар эзэмших сонирхол хэрэгцээ,

хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн сургалтыг уян хатан зохион байгуулах, мэргэжлийн боловсрол, сургалтын чанартай үйлчилгээ үзүүлэх;

16.1.3.байгууллагын чанарын баталгаажилтын механизм бүрдүүлж, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, сургалтын үр дүнг тасралтгүй хянаж сайжруулах;

16.1.4.багш, ажилтан, суралцагчдын үр бүтээлтэй ажиллах, сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, тэднийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, ажлын байрны эрэлтийн мэдээллээр хангах;

16.1.5.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дүрэм, багш, ажилтны ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтийг хангах;

16.1.6.техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллага нь удирдах зөвлөлөөс тогтоосон хэмжээгээр суралцагчдаас сургалтын төлбөр авч болно;

16.1.7.хүүхэд, залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажил, хөдөлмөрт бэлтгэх, анхан шатны мэдэгдэхүүн, арга барил эзэмшүүлэхэд чиглэсэн тусгайлсан хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага дангаар болон хамтран зохион байгуулна.

16.1.8.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын удирдлага, удирдах зөвлөлийг байгуулах, ажиллуулахтай холбогдсон харилцааг боловсролын тухай хуулийн 33, 36 дугаар зүйл, энэ хуулийн 14.2-ийн заалтын дагуу зохицуулна.

16.1.9.сургалтын байгууллага нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

16.2. Багшид тавигдах шаардлага

16.2.1.чадамжийн сургалтын төвийн багш нь үйлдвэрлэл, үйлчилгээнд ажилласан туршлагатай, сургах зүйн чадамж эзэмшсэн гэрчилгээтэй байна;

16.2.2.мэргэжлийн боловсролын багш нь бакалавр түүнээс дээш зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэлд ажилласан туршлагатай, багшлах эрхийн үнэмлэхтэй байна;

16.2.3.техникийн боловсролын багш нь бакалавр түүнээс дээш зэрэгтэй, үйлдвэрлэлийн болон судалгаа, шинжилгээний арга зүйн дадлага туршлагатай, багшлах эрхийн үнэмлэхтэй байна;

16.2.4.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллаж байгаа багш нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирсон арга зүй эзэмшсэн байна.

16.2.5.багшлах эрх олгох, хасах болон багшид мэргэшлийн зэрэг олгох журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална;

16.3. Багшийн эрх:

16.3.1.техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 44.1-д зааснаас гадна дараах эрхтэй:

16.3.1.1.үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мэргэжлийн дагуу гэрээгээр ажиллах, мэргэшил дээшлүүлэх, зөвлөгөө өгөх;

16.3.1.2. шинэ техник, технологи эзэмших, дадлага хийх;

16.3.1.3. бүтээлийн чөлөө авах;

16.3.1.4. багшид заах аргач багш, тэргүүлэх багш, зөвлөх багш гэсэн мэргэшлийн зэрэг авч болно.

16.4. Багшийн үүрэг:

16.4.1. техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 44.2-т зааснаас гадна дараах үүрэгтэй:

16.4.1.1. сургалтын идэвхитэй, шинэлэг арга зүйг эзэмшиж, мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцагчид мэргэжил эзэмшүүлэх, мэргэшлийн ур чадвар олгох;

16.4.1.2. сургалтын явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллах;

16.4.1.3. мэргэжлийн багш аж ахуйн нэгж, байгууллагад жил бүс үйлдвэрлэлийн дадлага хийж мэргэжлийн ур чадвараа ахиулах;

16.4.1.4. инновац, шинэ техник, технологи, стандарт, норматив, хөдөлмөр зохион байгуулалтын дэвшилтэт арга барил судлах, гадаад хэл, дижитал ур чадварт суралцах, сургалтад нэвтрүүлэн ашиглах;

16.4.1.5. багш нь хоёр жил тутамд мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, гурван жил тутамд мэргэшил, ур чадвараа үнэлүүлсэн байх;

16.4.1.6. багшийн ёс зүйн дүрмийг баримтлах;

16.4.1.7. сургалтын байгууллага болон багш, суралцагчийн сургалтын ажил, эрүүл мэнд, аюулгүй байдал, эрх ашигт сөрөг нөлөө үзүүлэх аливаа үйл ажиллагааг таслан зогсоох, хориглоход биечлэн оролцох.

16.5. Багш, ажилтан нь дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

16.5.1. хөдөлмөрийн шинж чанар, мэргэжлийн онцлогт тохирсон цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх олговор, шагнал урамшуулал авах, хуульд заасан бусад хөнгөлөлт эдлэх;

16.5.2. багш, ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацааг хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна;

16.5.3. хөдөлмөрийн онцлогийг харгалзан мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын захирал, дэд захиралд ажлын 15, багш, дотуур байрны багш, нийгмийн ажилтан, арга зүйч, сэтгэл зүйч, сургалтын менежерт ажлын 33 өдрийн нэмэгдэл амралт тус тус олгох;

16.5.4. энэ хуулийн 16.2.2. болон 16.2.3.-т заасан багшийн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох журмыг санхүү, төсвийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран, сургалтын цагийн ачаалал тогтоох, тооцох журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

16.5.5. энэ хуулийн 16.2.2. болон 16.2.3.-т заасан байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 43.1.-д заасан баталгаагаар хангагдахаас гадна сургалтын байгууллагад тасралтгүй ажилласан таван жил тутамд нэг удаа арван сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас олгоно;

16.5.6. энэ хуулийн 16.2.2. болон 16.2.3.-т заасан байгууллагын захирал, сургалтын менежер, арга зүйч-багш, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, номын санч, хүний нөөцийн болон нийгмийн түншлэл, үйлдвэрлэлийн сургалт хариуцсан арга зүйч, дотоод чанарын баталгаажилт, статистик хариуцсан ажилтан, эмч болон бүс хариуцсан арга зүйн албаны менежер, арга зүйчид тасралтгүй ажилласан таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас олгоно.

16.6. Суралцагчийн эрх, үүрэг:

16.6.1. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагч Боловсролын тухай хуулийн 45.1-д зааснаас гадна дараах эрхтэй:

16.6.1.1. сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй ашиглах;

16.6.1.2. үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад дадлагын ажил хийхдээ үндсэн болон дагалдангийн орон тоон дээр ажилласан бол хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх;

16.6.1.3. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгч нь дараагийн шатны боловсрол, сургалтын байгууллагад үргэлжлүүлэн суралцах;

16.6.1.4. суралцагч цагийн хөдөлмөр эрхлэх, амралт, чөлөөт цагаараа аж ахуйн нэгжид ажиллаж цалин хөлс авах;

16.6.1.5. ерөнхий боловсролын сургуулийн сурагч, ажил хайж буй иргэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаатай танилцах, мэргэжлийн чиг баримжаа олгох болон сурталчилгааны хөтөлбөрт үнэ төлбөргүй хамрагдах, мэргэжлийн тохироцоо үнэлүүлэх, зөвлөгөө авах.

16.6.2. Боловсролын тухай хуулийн 45.2-т зааснаас гадна үйлдвэрлэлийн дадлагын ажлын үед аж ахуйн нэгж, байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны дүрэм, энэ хуулийн 13.4-т заасан гэрээний заалтыг сахин биелүүлэх үүрэгтэй.

17 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх

17.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь иргэнийг эзэмшсэн боловсрол, ур чадварын түвшин, хэрэгцээ, сонирхолд үндэслэн зохих мэргэжил, энэ хуулийн 14.2-т заасан ангиллын сургалтад элсүүлнэ.

17.2. Техникийн боловсролын сургалтын байгууллагад бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой иргэнийг элсүүлнэ.

17.3. Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх мэргэжлийн чиглэл, хяналтын тоо, элсэлтийн үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн энэ хуулийн 8.1-т заасан байгууллага батална.

17.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад гадаад иргэн суралцахтай холбоотой асуудлыг Гадаад иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

17.5. Суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэх бөгөөд эрэлтийн судалгааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн мэргэжлийн судалгааны байгууллага гаргана.

17.6. Ажил, мэргэжлийн тодорхой чадамжийг эзэмших, ур чадвараа дээшлүүлэх, давтан суралцах хүсэлтэй иргэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад нас, боловсролын түвшин харгалзахгүйгээр сургалтад хамрагдана.

18 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын нийгмийн түншлэл

18.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын чиглэлээр нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, ажил олгогч, ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоо, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, суралцагч, эцэг, эхчүүд хамтран нийгмийн түншлэлийг бүрдүүлж, зөвлөлийн хэлбэрээр ажиллана.

18.2. Нийгмийн түншлэл нь мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого, үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн оролцоо, байнгын хамтын ажиллагааг хангах, үйлдвэрлэлийн дадлагыг чанаржуулах, суралцагч, төгсөгчийн мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэхэд ажил олгогч, түншүүдийн санаачилга, үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн бүтээмж, эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ.

18.3. Нийгмийн түншлэлийн төлөөллийг дараах түвшинд бүрдүүлнэ:

18.3.1.үндэсний хэмжээний нийгмийн түншлэлийг Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагууд, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн нэгдсэн холбоод, ажил олгогч, төрийн бус байгууллагын тэнцвэртэй төлөөллөөс бүрдсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл;

18.3.2.салбар, орон нутгийн түвшний түншлэлийг яам, агентлаг, нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, ажил олгогч, мэргэжлийн холбоодын төлөөллөөс бүрдсэн салбарын зөвлөл;

18.3.3.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын түвшний түншлэлийг сургалтын болон аж ахуйн нэгж, байгууллага, мэргэшсэн инженер, техникийн ажилтан, суралцагч, төгсөгч, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн сургалтын байгууллагын удирдах зөвлөл.

18.4. Энэ хуулийн 6.3-д заасан Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.

18.5. Зөвлөл, түүний ажлын албаны чиг үүрэг, ажиллах зарчим, зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага, эрх, үүрэг, хариуцлагыг энэ хуулийн 18.4-т заасан дүрмээр зохицуулна.

18.6. Зөвлөлийн бүрэлдэхүүн дэх хувийн хэвшлийн төлөөллийг Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, үндэсний хэмжээнд төлөөлөх эрх бүхий гишүүнчлэлтэй мэргэжлийн холбоо, ажил олгогч байгууллагын хамтран зохион байгуулсан хурлаас сонгогдсон гишүүд хэрэгжүүлнэ.

18.7. Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.7.1.мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх урт, дунд болон богино хугацааны бодлого, хөтөлбөрийг хэлэлцэж дүгнэлт гаргах;

18.7.2.ажиллах хүчний талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогч, холбогдох байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, зөвлөмжөөр хангах;

18.7.3.мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт, мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог хөгжүүлэх талаар мэдээлэл, илтгэл хэлэлцэх, тогтоол, зөвлөмж гаргах, чиглэл өгөх;

18.7.4.мэргэшлийн түвшний хүрээг мэргэжлийн боловсрол, сургалтын хүрээнд хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар хангах;

18.7.5.мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын зөвлөлийн боловсруулсан ажил, мэргэжлийн стандартыг хэлэлцэж дүгнэлт гаргах;

18.7.5.мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих;

18.7.6.аж ахуйн нэгж, байгууллагыг түшиглэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйлдвэрлэл-сургалт, дадлага, үнэлгээ, судалгаа шинжилгээ, инновац, гарааны компани болгон ажиллахад дэмжлэг үзүүлэх;

18.7.7.мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой олон улсын гэрээ, конвенцид Монгол Улс нэгдэн орох асуудлаар санал гаргах;

18.7.8.гаргасан шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих;

18.7.9.зөвлөл ажлаа Засгийн газарт тайлагнах;

18.7.10.хууль тогтоомжид заасан бусад.

18.8. Эдийн засгийн салбар, орон нутагт ажиллах салбарын зөвлөлийг энэ хуулийн 6.3-д заасан зөвлөл байгуулж дүрмийг батална.

18.9. Нийгмийн түншлэлийн байгууллага нь дараах чиглэлээр хамтран ажиллана:

18.9.1.мэргэжлийн боловсрол, сургалтын талаархи төрийн бодлого боловсруулахад оролцох, сургалтын үйл ажиллагаанд санал, зөвлөмж өгөх;

18.9.2.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9.1-д нийцүүлж ажил, мэргэжлийн стандартыг салбарын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн тухайн салбарын асуудал эрхэлсэн сайд батлах бөгөөд мэргэжлийн боловсрол, сургалтын стандартыг энэ хуулийн 8.1-д заасан байгууллагын саналыг үндэслэн холбогдох техникийн хороо хэлэлцэн, дүгнэлт гаргах;

18.9.3.үйлдвэрлэлийн дадлагын сургалтад тавигдах шаардлага, зохион байгуулах журмыг Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж мөрдүүлэх;

18.9.4.сургалтын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах, сургалтын орчин, нөхцөлийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах, хандив тусалцаа үзүүлэх;

18.9.5. үйлдвэрлэлийн техник, технологийг шинэчлэх, судалгаа, туршилт хамтран явуулах;

18.9.6. үйлдвэрлэлийн сургалт, дадлага, төгсөлтийн үнэлгээг зохион байгуулахад хамтран ажиллах;

18.9.7. суралцагчийн сурлагын амжилт, мэргэжлийн ур чадварыг ажил олгогчдод мэдээлэх, дадлагажуулах, төгсөгчийн сонирхолд тулгуурлан ажлын байранд зуучлах, аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжих замаар ажлын байраар хангах;

18.9.8. багш, инженер-техникийн ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, багш нарын мэргэшил дээшлүүлэхэд хамтран ажиллах;

18.9.9. хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

18.10. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын удирдах зөвлөл нь орон нутгийн салбар зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлж болно.

19 дүгээр зүйл. Мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллагын эрх үүрэг

19.1. Аж ахуйн нэгж, байгууллага дараах эрх, үүрэгтэй:

19.1.1. мэргэжилтэн бэлтгэх, мэргэшил дээшлүүлэхтэй холбогдсон мэдээлэл, захиалгыг үндэсний хэмжээний мэдээллийн нэгдсэн системд байршуулах;

19.1.2. гэрээ, захиалгад сургалтын хөтөлбөрийн агуулга, суралцагчийн ур чадварт тавих эрэлт, шаардлагыг тодорхой тусгах, гэрээ, захиалгаар суралцагчийн сургалтын зардлыг төлөх;

19.1.3. мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих, сургалтын байгууллагыг бэхжүүлэх, сургалтын орчин бүрдүүлэх, шинэчлэхэд дэмжлэг, тусалцаа үзүүлэх, энэ чиглэлээр хууль тогтоомжид заасан зохих хөнгөлөлт эдлэх;

19.1.4. мэргэжлийн боловсрол, сургалтын нийгмийн түншлэлийн зөвлөлүүдэд төлөөллөө оролцуулах замаар мэргэжлийн боловсрол, сургалтыг удирдах, хөгжүүлэхэд оролцох.

19.1.5. иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн тохироцоо тодорхойлуулах, ажилтны мэргэшил дээшлүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох чиглэлээр хамтарсан сургалт зохион байгуулах;

19.1.6. эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлийн дагуу, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчийг хүлээн авч үйлдвэрлэлийн дадлага хийлгэх нөхцөл, боломжоор хангах, үр дүнг хамтран дүгнэх;

19.1.7. аж ахуйн нэгж, байгууллага нь суралцагчийн үйлдвэрлэлийн дадлагын ажлыг зохион байгуулж, мэргэжлийн ур чадвар олгох үүрэг бүхий дадлагажуулагч инженер-техникийн ажилтан ажиллуулах;

19.1.8. ажил олгогч үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулахдаа энэ хуулийн 13.3, 13.4, 13.5-д заасныг үндэслэн гурван талт гэрээ байгуулж, үндсэн болон дагалдангийн орон тоон дээр ажилласан дадлагажигчид гүйцэтгэсэн үүрэгт нь дүйцэхүйц цалин, хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй хэмжээгээр тогтоон олгоно;

19.1.9. аж ахуйн нэгж, байгууллага ажилтны мэдлэг, ур чадвар, гүйцэтгэлтэй холбоотой үнэлгээ хийж, мэргэшлийн түвшнийг мэргэжлийн стандарт, мэргэшлийн түвшний тодорхойлолтод харгалзуулан тогтоож мөрдөх.

19.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн нэгдэн орсон нийгэмлэг, холбооны төлөөлөл бүхий нийгмийн түншлэлийн байгууллагаас мэргэжлийн боловсрол сургалтын талаар гаргасан шийдвэр, удирдамж, зөвлөмжийг дагаж мөрдөнө.

ТАВДУГААР БҮЛЭГ

ЧАНАРЫН БАТАЛГААЖИЛТ

20 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажилт

20.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын хэрэгжилтийг үнэлэх, баталгаажуулах, иргэдийн мэргэжлийн ур чадвар, аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх баталгааг хангах үндсэн хэрэгсэл нь мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажилтын тогтолцоо байна.

20.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажилтад тусгай зөвшөөрөл, аттестатчилал, мэргэшлийн баталгаажуулалт, магадлан итгэмжлэл, гэрчилгээжүүлэлт хамаарна.

20.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн түвшний хүрээг тогтоох, дүйцүүлэх, хэрэгжилтийг хангах, хяналт тавих асуудлыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохицуулна.

21 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, татан буулгах

21.1. Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

21.2. Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

21.3. Төрийн бус өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг байгуулах асуудлыг үүсгэн байгуулагчдын хурлаар, өөрчлөх, татан буулгах асуудлыг тухайн байгууллагын удирдах зөвлөл нь хуульд заасан үндэслэлийн дагуу шийдвэрлэнэ.

21.4. Олон улсын хөтөлбөртэй, гадаадын хөрөнгө оруулалттай мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төрийн өмчийн оролцоотойгоор байгуулах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

21.5. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага татан буугдсан нөхцөлд суралцагчийг ижил төстэй мэргэжлийн сургуульд шилжүүлэн суралцуулах, бусад харилцааг зохицуулах асуудлыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

21.6. Татан буугдсан төрийн ба төрийн бус өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулах хугацаандаа гаргасан тушаал шийдвэр, суралцагчдын нэрс, төгсөгчдийн боловсролын бичиг баримтын хуулбар, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг сургалтын байгууллагын үйл ажиллагаатай

холбогдох баримт бичгийг татан буугдах шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор Үндэсний төв архивд хүлээлгэн өгнө.

21.7. Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11-14 дүгээр зүйл, Боловсролын тухай хуулийн 21-24 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулах ба тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага, загварыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.8. Бусад сургалтын төв болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасны дагуу зохион байгуулсан сургалтыг зохих журмын дагуу бүртгүүлсэн хуулийн этгээд эрхэлнэ.

21.9. Энэ хуулийн 14.2.1-д заасан чадамжийн сургалтын төвийг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

22 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын чанарын үнэлгээ

22.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөр, багшлахуй болон суралцахуйн явц, үр дүн, үйл ажиллагаандаа тогтмол үнэлгээ хийж, удирдлагын шийдвэрт тусган, чанарын дотоод баталгаажилтыг хангаж ажиллана.

22.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг аттестатчилах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

22.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь олон улс, үндэсний хэмжээнд байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэх, чанарын удирдлагын стандартыг нэвтрүүлэхэд сайн дурын үндсэн дээр хамрагдана.

23 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих

23.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааны тодорхой чиглэлээр үнэлгээ, хяналт шалгалт хийх ажлыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санаачилгаар зохион байгуулж болно.

23.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.

24 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, гэрчилгээжүүлэлт

24.1. Суралцагчийн мэдлэг, ур чадвар, төлөвшлийг дүгнэх, чанарын үнэлгээ хийх журмыг боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

24.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг сургалтын явцад үнэлэхдээ энэ хуулийн 24.1-т заасан журмын дагуу сургалтын стандартын хэрэгжилтийг дүгнэнэ.

24.3. Төгсөгч, иргэнийг үнэлэх мэргэшлийн түвшин тогтоох баталгаажуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын хэрэгжилтийг багшийн үнэлгээ, сургалтын байгууллагын шалгалтын болон мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнээг тодорхойлно.

24.5. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг албан болон албан бус сургалтын хэлбэрээр эзэмшиж үнэлгээнд тэнцсэн иргэнд дараах боловсролын баримт бичгийг олгож гэрчилгээжүүлнэ:

24.5.1. мэргэжлийн тодорхой түвшний ур чадвар олгох сургалтад хамрагдаж чадамж эзэмшсэн иргэнд чадамжийн гэрчилгээ;

24.5.2. суурь боловсрол эзэмшсэн иргэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцаж, мэргэжил болон бүрэн дунд боловсролыг хамтад нь эзэмшсэн бол мэргэжлийн боловсролын үнэмлэх;

24.5.3. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцаж мэргэжил эзэмшсэн иргэнд мэргэжлийн үнэмлэх;

24.5.4. бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой иргэн техникийн боловсрол эзэмшсэн бол техникийн боловсролын диплом;

24.5.5. мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллага нь иргэний өмнөх мэдлэгийг хүлээн зөвшөөрч, баталгаажуулан зохих түвшний баримт бичгийг олгоно.

24.6. Энэ хуулийн 24.5-т заасан болон сургалтын баримт бичгийн загвар, баримт бичиг бүрдүүлэх, олгох журмыг боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

25 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын статистик, мэдээлэл

25.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын статистик хөтлөх, бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн санг үүсгэн байгуулах, сангийн дүрмийг баталж мөрдүүлэх, удирдлагаар хангах, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих ажлыг энэ хуулийн 8.1-т заасан байгууллага хариуцна.

25.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын мэдээллийн нэгдсэн сан (цаашид "мэдээллийн нэгдсэн сан" гэх) нь мэргэжлийн боловсрол, сургалтын болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй холбоотой бодит мэдээллээр төр, иргэд, аж ахуйн нэгж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, олон нийтэд үйлчлэх чиг үүрэгтэй байна.

25.3. Мэдээллийн нэгдсэн санг цахим хэлбэрээр ажиллуулах бөгөөд сангийн үйл ажиллагаа, үйлчилгээний төлбөртэй холбоотой асуудлыг мэргэжлийн боловсролын сургалтын төрийн захиргааны байгууллага зохицуулна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ

26 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

26.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийг мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан хэрэгжүүлэх бөгөөд сангийн санхүүгийн удирдлагыг мэргэжлийн боловсрол, сургалтын төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

26.2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

27 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлогын эх үүсвэр

27.1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

27.1.1. улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

27.1.2. орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

27.1.3. гадаад улс, олон улсын байгууллагаас мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих зорилгоор олгосон зээлийн хөрөнгө, буцалтгүй тусламж;

27.1.4. гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс өгсөн хандив, тусламж;

27.1.5. аж ахуйн нэгж, байгууллагаас энэ хуулийн 29.4-д заасны дагуу төвлөрүүлсэн хөрөнгө;

27.1.6. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө;

27.1.7. үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого;

27.1.8. техникийн боловсролын сургалт, захиалгат болон насанд хүрэгчдийн сургалтын төлбөр;

27.1.9. бусад эх үүсвэр.

28 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн зарцуулалт

28.1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг дараах зориулалтаар хуваарилан зарцуулна:

28.1.1. төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тогтмол зардал, түүнчлэн сурагчийн дотуур байрны нийт зардал;

28.1.2. өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэг;

28.1.3. багш, ажилтанд олгох тэтгэмж;

28.1.4. багш, хүний нөөцийг мэргэшүүлэх, давтан сургах, багшийн ур чадварын түвшинг тогтоох зардал;

28.1.5. суралцагчийг ажлын байранд бэлтгэх, гарааны бизнес эрхлэх боломжийг дэмжих, мэргэшил дээшлүүлэх, давтан сургах зардал;

28.1.6. сургалтын байгууллагын дадлагын материалын зардал;

28.1.7. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын аттестатчилал, чанарын хяналтын зардал;

28.1.8. мэргэжлийн боловсрол, сургалтын хэвлэмэл болон цахим сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, түүнтэй холбогдон гарах үйл ажиллагааны зардал;

28.1.9. үндэсний болон олон улсын мэргэжлийн ур чадварын тэмцээнд бэлтгэх, оролцох зардал;

28.1.10. үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн үйл ажиллагааны зардал;

28.1.11. салбарын хэмжээнд тогтмол хийгдэх судалгаа, шинжилгээний зардал.

29 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлагын төсөв

29.1. Улсын төсвөөс тухайн жилд Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд олгох хөрөнгийн хэмжээг Улсын Их Хурал тухайн жилийн төсөвт тусгаж батална.

29.2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд орон нутгийн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж батална.

29.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.1.13-т заасны дагуу хуваарилсан хөрөнгийг мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан тухайн жилийн төсөвт тусгаж батална.

29.4. Салбар, үйлдвэрийн онцлогоос хамааран аж ахуйн нэгж, байгууллага нь мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд цалингийн сангаасаа энэ хуулийн 6.3-д заасан Зөвлөлөөс тогтоосон тодорхой хувь хэмжээгээр санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

29.5. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгийг энэ хуулийн 26.2-т заасан журмаар зохицуулна.

29.6. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн тухайн жилийн орлого, зарлагын төсвийн хуваарийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн энэ хуулийн 6.3-д заасан Зөвлөл батална.

29.7. Энэ хуулийн 28.1.2-д заасан мэргэжлийн өөрийн өртөг тооцох аргачлалыг мэргэжлийн боловсрол, сургалтын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

29.8. Төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захирал нь энэ хуулийн 15.2-т заасан үйл ажиллагаанаас олсон орлогоо захиран зарцуулах эрхийг эдэлнэ.

29.9. Төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын өөрийн орлого, түүнийг зарцуулах, хяналт тавих, тайлагнах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

29.10. Төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага гадаадын буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтад хамрагдахдаа мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөнө.

29.11. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын өөрийн орлогын хэмжээтэй холбоотойгоор улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг багасгахыг хориглоно.

29.12. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн үйл ажиллагааны орлого бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

29.13. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчин, дадлагын газрыг засварласан, тоног төхөөрөмжөөр хангасан, энэ хуулийн 16.3.2.3-д заасан багшийг дадлагажуулсан зардал, аж ахуйн нэгж, байгууллагаас мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд өгсөн санхүүгийн дэмжлэг, хандив сургалтын байгууллагад үзүүлсэн санхүүгийн дэмжлэгийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15.1.4, 15.1.5, 15.1.6, 15.1.9 дүгээр заалтыг үндэслэн татвар ногдох орлогоос хасаж тооцно.

30 дугаар зүйл. Сангийн тайлан гаргах

30.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлагын тайланг дор дурдсан хугацаанд гаргаж, энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөл, мэргэжлийн боловсрол, сургалтын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ:

30.1.1. улирлын нэгдсэн тайланг дараа улирлын хоёр дахь сарын 5-ны дотор;

30.1.2. жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор.

ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

31 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

31.1. Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

31.2. Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

32 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

32.1. Энэхүү хуулийг 202 ... оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны дүгээр сарын-ны өдөр

Улаанбаатар хот

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдөр баталсан Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны дүгээр сарын-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.7. дах заалтыг 6.3.8. болгож өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.7. дах заалтад дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

"6.3.7.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчийг ажлын байртай болгоход дэмжлэг үзүүлэх"

3 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд дор дурдсан агуулгатай өөрчлөн найруулсугай:

1/ 7 дугаар зүйлийн 7.1. дэх хэсэг:

"7.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ажил олгогч энэ хуульд заасны дагуу хамаарна."

2/ 11 дугаар зүйлийн 11.3. дах хэсэг:

"Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 12.2-т заасан байгууллагатай хамтран хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж болно."

3/ 12 дугаар зүйл:

12 дугаар зүйл. Малчин, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих

4/ 12 дугаар зүйлийн 12.1. дэх хэсэг:

12.1. Малчин, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих арга хэмжээ нь иргэний ганцаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхлэх санаачилгыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулах, жижиг зээл, санхүүгийн дэмжлэг, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх зэрэг арга хэрэгслээр дэмжин туслах хэлбэртэй байна.

5/ 12 дугаар зүйлийн 12.2. дах хэсэг:

12.2. Малчин, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих зориулалттай жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох бөгөөд уг сангаас олгох жижиг зээлийг банкаар дамжуулан олгоно.

6/ 23 дугаар зүйлийн 23.1.7. дах заалт:

23.1.7. малчин, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны дүгээр сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. дэх хэсэгт "мэргэжил олгох төв" гэснийг "чадамжийн сургалтын төв" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй.

"Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд мэргэжил эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд заасны дагуу зохицуулна"

3 дугаар зүйл. Энэ хуулийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2021 оны дүгээр сарын-ны өдөр

Улаанбаатар хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлд дор дурдсан агуулга бүхий шинэ хэсгийг нэмсүгэй:

"Мэргэжлийн боловсрол, сургалтын баримт бичгийн загвар, баримт бичиг бүрдүүлэх, түүнийг хөтлөх, олгох журмыг боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална"

2 дугаар зүйл. Боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлд дор дурдсан агуулга бүхий шинэ хэсгийг нэмсүгэй:

"Бүрэн дунд боловсрол олгох сургалтыг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага эрхэлж болно. Бүрэн дунд боловсрол олгох сургалтын цөм хөтөлбөрийн агуулгын багтаамжийг мэргэжлийн боловсрол, сургалтын болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран шийднэ."

3 дугаар зүйл. Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1. дэх хэсэгт "15.7.4." гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2021 оны дүгээр сарын-ны өдөр

Улаанбаатар хот

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дээд боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2. дох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Дээд боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дах хэсгийг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

"5.3. Их, дээд сургууль харьяалалдаа коллеж, технологийн коллеж, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, эрдэм шинжилгээний хүрээлэн, ахлах сургуультай байж болно."

3 дугаар зүйл. Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн "элсэлтийн ерөнхий шалгалтад орсон" гэдгийг хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны дүгээр сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**АЖИЛЛАХ ХҮЧ ГАДААДАД ГАРГАХ, ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТЭН
АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дах хэсэгт дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

"энэ хуулийн 8.2.5.-г хангаагүй гадаадын иргэнийг ур чадварын түвшин тогтоох үнэлгээнд хамруулах ажлын Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан байгууллагаар хийлгэх"

3 дугаар зүйл. Энэ хуулийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны дүгээр сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.7.4, 15.7.5 дах заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.9 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай заалтыг нэмсүгэй:

1/ 15 дугаар зүйлийн 15.9.2. дох заалт:

"15.9.2.мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх"

2/ 15 дугаар зүйлийн 15.9.3. дах заалт:

"15.9.3.мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ мэргэжлээр сургалт явуулах"

3/ 15 дугаар зүйлийн 15.9.4 дэх заалт:

"15.9.4.олон улсын хөтөлбөртэй болон гадаадын хөрөнгө оруулалттай мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгуулах"

3 дугаар зүйл. Энэ хуулийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны дүгээр сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ
ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд дор дурдсан агуулгатай өөрчлөн найруулсугай:

1/ 10 дугаар зүйлийн 10.1.4. дэх заалт:

"10.1.4.орон нутгаас хамгийн их ажиллах хүч авсан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчийг дадлагажуулсан"

2/ 16 дугаар зүйлийн 16.1.1. дэх заалт:

"16.1.1.тендерт оролцогчийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвартай болохыг гэрчилсэн баримт бичиг"

2 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1. дэх хэсэгт дор дурдсан агуулга бүхийн заалтыг нэмсүгэй:

"мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дадлагын бараа, материал худалдан авах"

3 дугаар зүйл. Энэ хуулийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ